## “ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Хариуцах нэгж, /ажилтан/ |
|---|---|---|---|---|
| **Нэг. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж, тусламж дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | |
| 1. | УИХ, Засгийн газраас баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагч нарын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож мөрдөнө. | 1.1 Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоох тухай УИХ, Засгийн газраас баталсан шийдвэрийг хэрэгжүүлэх | Тухай бүр | ТЗУГ /Э.Бадамсүрэн/ |
| 2. | Цалингийн нэмэгдэл, суутгал, шимтгэл зэргийг нэг бүрчлэн тусгасан мэдээллийг сар бүр тухайн албан тушаалтанд өгч байна. | 2.1 Албан хаагчдын сар бүрийн цалин, нэмэгдэл, урамшууллын талаарх мэдээллийг сар бүр цахим хэлбэрээр албан хаагчдад хүргэх | Сар бүр | БТГ, ХОҮХ /О.Очгэрэл / |
| 3. | Төрийн захиргааны албан хаагчийн төрийн алба хаасан хугацааг тодорхойлж, нэмэгдэл олгох, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв шинээр олгох, ахиулах, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан шийдвэрлэнэ. | 3.1 Яамны төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагчдын төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох асуудлыг шийдвэрлэх | 1 дүгээр сард | ТЗУГ / Э.Бадамсүрэн / |
| | | 3.2 Яамны төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийн судалгааг шинэчлэн гаргаж, зэрэг дэв олгох, зэрэг дэвийг нэмэгдүүлэх асуудлыг шийдвэрлэх | 1 дүгээр сард | ТЗУГ / Э.Бадамсүрэн / |
| 4. | Ажилтнуудад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна бусад хэлбэрээр урамшуулах боломжийг судлан хууль тогтоомжид нийцүүлэн төрийн дээд одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах болон гадаад, дотоодод сургалтанд хамруулах, мэргэжил дээшлүүлэх зэргээр урамшуулна. | 4.1 Албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлсэн үнэлгээг үндэслэн улирлын болон жилийн эцсийн урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх | Улирал бүр | ТЗУГ /Э.Бадамсүрэн/ БТГ, ХОҮХ /О.Очгэрэл/ |
| | | 4.2 Тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан ажилдаа амжилт гарган ажиллаж байгаа албан хаагчдыг төрийн дээд одон, медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах асуудлыг судлан шийдвэрлүүлэх, дагалдах мөнгөн шагналыг олгуулах. | Тухай бүр | ТЗУГ /П.Насанжаргал/ Газар, хэлтэс |
| | | 4.3 Жилийн эцсийн ажлын үзүүлэлтийг үндэслэн идэвх санаачлагатай, үр бүтээлтэй ажилласан албан хаагчдыг Сайдын болон яамны Төрийн нарийн бичгийн даргын нэрэмжит шагналаар шагнах. | 12 дугаар сард | ТЗУГ /П.Насанжаргал/ Газар, хэлтэс |
| 5. | Албан хаагчдын ээлжийн амралт, нөхөх төлбөр, тэтгэвэр тэтгэмж, буцалтгүй тусламж олгох зэрэг асуудлыг Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад шийдвэр, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу | 5.1 Албан хаагчдын улсад болон төрд ажилласан жилийг нэг бүрчлэн тулган шалгаж, түүнд үндэслэн ээлжийн амралт олгох хугацааг тогтоож, хуваарийг батлуулж, хуваарийн дагуу ээлжийн амралтыг олгох, амралтын тооцоо хийх ажлыг зохион байгуулах | Жилдээ | ТЗУГ / Э.Бадамсүрэн / |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | шийдвэрлэнэ. | 5.2 Албан хаагчдад нөхөх төлбөр, тэтгэвэр тэтгэмж, буцалтггүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон байгууллагын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тухай бүр шийдвэрлэх | Жилдээ | ТЗУГ /Э.Бадамсүрэн / БТГ, ХОҮХ /О.Очгэрэл/ |
| | | 5.3 Албан хаагчдын эцэг эхийн насны ой тэмдэглэх, үр хүүхэд, төрсөн ах дүү нь хурим хийх, сургууль төгсөх, диплом, эрдмийн зэрэг хамгаалах зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантай тохиолдолд цалинтай чөлөө олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх | Тухай бүр | ТЗУГ /Э.Бадамсүрэн / |
| | | 5.4 Хөдөлмөрийн дотоод журамд заасан нөхөх төлбөр, тэтгэвэр, тэтгэмж, буцалтгүй тусламжийн хэмжээнд өөрчлөлт оруулна. | 1 дүгээр сард | ТЗУГ /Э.Бадамсүрэн/ |
| **Хоёр. Албан хаагчдыг орон сууцаар хангах, амьдрах нөхцлийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | |
| 6. | Албан хаагчдын орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн тодорхой төсөл, хөтөлбөрийг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 6.1 Яамны болон зарим харьяа байгууллагын албан хаагчдын орон сууц барих төслийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх | Жилдээ | ТЗУГ /Ажлын хэсэг/ |
| 7. | **МИАТ ТӨХК-ийн Баянзүрх дүүрэгт байрших газар дээр зам, тээврийн салбарын албан хаагчдад зориулсан хотхон барих ажлыг зохион байгуулна.** | 7.1. Холбогдох шийдвэрийг албажуулж, салбарын албан хаагчдад хөнгөлттэй нөхцлөөр орон, сууцад хамруулах ажлыг зохион байгуулах | Жилдээ | ТЗУГ /Б.Болор-Эрдэнэ/ |
| 8. | Албан хаагчдыг зуслангийн газар өмчилж авахад нь туслалцаа үзүүлэх, зуслангийн байр барихад нь байгууллагын зүгээс санхүүгийн болон зохион байгуулалтын дэмжлэг үзүүлэх арга хэлбэрийг эрэлхийлнэ. | 7.1 Албан хаагчдад зуслангийн газар олгуулах асуудлыг судлаж шийдвэрлүүлэх | II улиралд | ТЗУГ / Э.Бадамсүрэн / |
| 9. | Төрийн албан хаагчийг амьдрах орчин нөхцлөө сайжруулах, орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөлийг нь сайжруулахад хууль тогтоомжийн дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ. | 8.1.Албан хаагчдын орон сууцны судалгааг төрөлжүүлэн гаргаж, түүнд үндэслэн орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцлийг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх талаар судалж, санал боловсруулах | Жилдээ | ТЗУГ Газар, хэлтэс |
| | | 8.2 Албан хаагчдыг орон сууцны болон бусад зээл авахад нь шаардлагатай тодорхойлолт, мэдээллийг гаргаж өгөх | Жилдээ | ТЗУГ / Э.Бадамсүрэн / |
| **Гурав. Ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх зорилтын хүрээнд:** | | | | |
| 10. | Төрийн албан хаагчийн ажлын тушаалын | 9.1 Албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног | Жилдээ | БТГ, ХОҮХ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд тухайн албан тушаалд шаардлагатай тоног төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийг тодорхой зааж, түүний дагуу хангалтыг хийнэ. | төхөөрөмж, эд хогшил, техник хэрэгслийн хэрэгцээг судлан тогтоож, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах замаар шийдвэрлэх | | /З.Цэрэнгомбо Х.Баярзул/ |
| 11. | Албан үүргээ гүйцэтгэж байх үед нь хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас төрийн албан хаагч, түүний гэр бүл гишүүнийг хамгаална. | 10.1 Албан үүргээ гүйцэтгэж байхдаа тулгарч болзошгүй аливаа хүчирхийлэл, заналхийлэл, доромжлол, гүтгэлэг, хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах талаар албан хаагчдад эрх зүйн зөвлөгөө өгч, сургалт зохион байгуулах | Жилдээ | ТЗУГ, ХХ /С.Мяндасмаа Б.Цэнд/ |
| **Дөрөв. Албан хаагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлж, дэмжлэг үзүүлэх зорилтын хүрээнд:** | | | | |
| 12. | Мэргэжлийн болон төрийн алба хаах өндөр ур чадвартай, өөрийгөө болон бусдыг байнга хөгжүүлдэг албан хаагч, хамт олныг бүрдүүлэхэд анхаарна. | 11.1 Хүний нөөцийн бодлогын хүрээнд шинэ, залуу албан хаагчдад зориулсан сургалтыг зохион байгуулах | Жилдээ | ТЗУГ / П.Насанжаргал/ |
| 13. | Яамны албан хаагчдын сургалтын хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг яамны жил бүрийн төсөвт тусгаж шийдвэрлэнэ. | 12.1 Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдыг сургах 2019 оны сургалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| 14. | Төрийн өмчийн их, дээд сургуулиудтай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд тус яамны албан хаагчдыг мэргэшүүлэх ажлыг зохион байгуулна. | 14.1 Төрийн өмчит их, дээд сургуулиудтай хамтран ажиллах санамж бичгийн байгуулж, богино, урт хугацааны сургалт, магистр, докторын сургалтад албан хаагчдыг хамруулна. | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| | | 14.2 Төрийн өмчит их, дээд сургуультай хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хөнгөлттэй үнээр магистр, докторын сургалтад хамруулна | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| | | 14.3 Төрийн өмчит их, дээд сургуульд тус яамны 1-2 албан хаагчийг төрийн зардлаар сургах асуудлыг судалж шийдвэрлэнэ. | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| | | 14.4 Тус яамны албан хаагчдаар төрийн өмчит их, дээд сургуульд багшлах, төгсөлтийн ажил удирдах боломжоор хангана. Бүртгэл судалгаа хөтлөнө. | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| 15. | Төрийн албан хаагчдад зориулан тодорхой сэдвийн хүрээнд, үе шаттай сургалтыг зохион байгуулах талаар Удирдлагын академитай | 13.1 Засгийн газрын захиалгын дагуу Удирдлагын академид зохион байгуулагдах богино хугацааны сургалтуудыг хамтран зохион байгуулж, сургалтад | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хамтран ажиллана. | нэгжийн удирдлага, мэргэжилтнүүдийг хамруулах | | |
| | | 13.2 Авлигтай тэмцэх газраас зохион байгуулагдах богино хугацааны сургалтуудыг хамран зохион байгуулж, сургалтад газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүдийг хамруулах | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| | | 13.3 Төрийн албан хаагчийн мэргэшүүлэх сургалт, төрийн удирдлагаар мэргэшүүлэх "Гараг"-ийн болон магистрын зэрэг олгох сургалтад 2-оос доошгүй албан хаагчийг төрийн зардлаар сургах | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| | | 13.4 Албан хаагчдыг ажлаас нь хөндийрүүлэхгүйгээр бодлогын баримт бичиг боловсруулах, төрийн захиргааны онолын болон албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр ажлын байран дахь сургалтыг зохион байгуулах | II-III улиралд | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| 16. | Бие даан болон хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах болон хэлний сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдыг дэмжиж, мэдлэг, мэргэшлээ дээшлүүлэх нөхцөл боломцоогоор хангана. | 14.1 Хувиараа мэргэжил эзэмших, мэргэшлийн зэрэг ахиулах сургалтад хамрагдаж байгаа албан хаагчдад дэмжлэг үзүүлж, цалинтай чөлөө олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх | Тухай бүр | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| | | 14.2 Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх асуудлыг албан хаагчдын үр дүнгийн гэрээнд мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт болгон тусгаж, албан хаагчдын англи хэлний түвшинг тогтоох. | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| 17. | Төрийн албан хаагчийг 60 хүртэлх хоногийн хугацаагаар эрх бүхий байгууллагын шийдвэрийн дагуу төрийн хөрөнгөөр дотооддоо давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэхэд түүний эрхэлж байгаа албан тушаалын цалинг нь олгоно. | 15.1 Албан хаагчдыг 60 хүртэлх хоногийн хугацаагаар сургалтад хамрагдах тохиолдолд цалинтай чөлөө олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тухай бүр шийдвэрлэх | Тухай бүр | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| 18. | Төрийн албан хаагчийн багаар ажиллах чадварыг сайжруулах, тодорхой сэдвийн хүрээнд төсөл бичиж, илтгэл тавих чадварыг сайжруулна. | 16.1 Тодорхой сэдвийн хүрээнд төрийн албан хаагчдын төсөл бичих уралдааныг зохион байгуулж, амжилттай оролцсон албан хаагчдад урамшуулал олгох. | I-II-р улиралд | ТЗУГ /Э.Бадамсүрэн П.Насанжаргал/ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 19. | Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх талаар шинэ санал, санаачилгыг дэмжиж ажиллана. | 17.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, цахимжуулах ажлын хүрээнд залуучуудын дунд уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах | III-IV-р улиралд | ТЗУГ /А.Оюунболд Ш.Мөнхбулган/ |
| 20. | Ахмад төрийн албан хаагчдын сургамж, зөвлөгөөг залуучуудад хүргэх, тэднээс суралцах, шинэ залуу боловсон хүчнийг төлөвшүүлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | 18.1 “Дурсамж, сургамж, зөвлөмж” арга хэмжээг зохион байгуулах. | III-IV-р улиралд | ТЗУГ /А.Оюунболд/ |
| **Тав. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалж, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх зорилтын хүрээнд:** | | | | |
| 21. | Ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулж нарийн мэргэжлийн үзлэг, шинжилгээ хийлгэх, эмчлүүлэх шаардлагатай ажилтнуудыг тухай бүрт нь эмчилгээ, сувилгаа хийлгэх, витаминжуулалтад хамруулах зэрэг эрүүл мэндийг хамгаалахад нь дэмжлэг туслалцаа үзүүлэх | 19.1 Албан хаагчдыг жил бүр гуравдугаар шатлалын эмнэлэгт урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах (Хавдар судлалын үндэсний төв, Төмөр замын нэгдсэн эмнэлэг) | 9-10 дугаар сард | ТЗУГ /Ш.Нямсүрэн/ |
| | | 19.2 Эмчийн ажиллах нөхцөлийг сайжруулж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслээр хангах | Жилдээ | БТГ, ХОҮХ /Г.Түвшинзаяа/ |
| | | 19.3 Төмөр замын нэгдсэн эмнэлэг, Өвөрхангай аймгийн 19.4 Хужирт сувилалтай хамтран ажиллах гэрээг байгуулан өрөө тохижуулж, Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг түргэн шуурхай, хүртээмжтэй байдлаар авах боломжийг бүрдүүлэх | 2-3 дугаар сард | ТЗУГ /Ш.Нямсүрэн/ БТГ, ХОҮХ /Г.Түвшинзаяа/ |
| 22. | Албан хаагчдыг аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, спортын уралдаан тэмцээн зохион явуулж байх, 7 хоногт нэг удаа спорт зааланд тоглуулах, аэробек, бүжгийн секц, усан бассейнд явуулах зэрэг төрөл бүрийн спортын арга хэмжээнд хамруулж, спорт, биеийн тамирын арга хэмжээг тогтмолжуулах | 20.1 УБТЗ ХНН-ийн Замчин спорт клубтэй гэрээ байгуулж, яамны албан хаагчдыг долоо хоногт нэг удаа спорт зааланд тоглох боломжийг хангах | Жилдээ | Биеийн тамир, спортын зөвлөл /Э.Бадамсүрэн/ |
| | | 20.2 Яамны болон салбарын 5 төрөлтийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах | 3-4 дүгээр сард | |
| | | 20.3 Засгийн газраас зохион байгуулдаг “Засгийн газрын цом”-ын 5 төрөлтийн тэмцээнд яамны багийг бүрдүүлж, бэлтгэл ханган оролцуулах | Жилдээ | |
| | | 20.4 Зам, тээврийн хөгжлийн яамны зүрх судасны өвчлөл, жингийн илүүдэлтэй албан хаагчдыг фитнесс клубт хөнгөлттэй үнээр хамрагдах боломжоор хангах | Жилдээ | |
| | | 20.5 Албан хаагч бүрт ажлын байран дахь дасгал, | Жилдээ | ТЗУГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хөдөлгөөнийг тогтмол цагт хийж хэвшүүлэх | | /Ш.Нямсүрэн/ |
| 23. | Төрийн албан хаагчдад эрүүл мэндийн болон эрүүл аж төрөх ёсны мэдлэг боловсрол олгоно. | 21.1 Эрүүл мэндээ хамгаалах, төрөл бүрийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн гарын авлага, ном товхимлоор ажиллагсдыг хангах, дотоод сүлжээнд мэдээлэл тогтмол байршуулах | Жилдээ | ТЗУГ /Ш.Нямсүрэн/ |
| | | 21.2 “Эрүүл аж төрөх ёс” сэдвийн хүрээнд нарийн мэргэжлийн эмч, мэргэжилтэнг урьж, жилд 2-оос доошгүй удаа албан хаагчдад яриа, таниулга хийх | Жилдээ | ТЗУГ /Ш.Нямсүрэн/ |
| **Зургаа. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байран дээрх сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд:** | | | | |
| 24. | Удирдах албан тушаалтны манлайллын чадавхыг хөгжүүлнэ | 22.1 Газар, хэлтэс, албаны дарга нарт зориулан “Төрийн захиргааны удирдлага, манлайлал” сэдвээр сургалт зохион байгуулах | 05 дугаар сард | ТЗУГ /П.Насанжаргал/ |
| 25. | Төрийн албан хаагч эрхэлсэн ажил, мэргэжлийнхээ дагуу оюуны бүтээл туурвихаар бол байгууллагын зүгээс эх бэлтгэх, хэвлэх, олшруулах, олон нийтэд сурталчлах зэрэгт нь дэмжлэг үзүүлнэ. | 23.1 Эрхэлсэн ажил, мэргэжлийнхээ дагуу оюуны бүтээл туурвисан албан хаагчид бүтээлээ хэвлүүлэх, сурталчлах болон багшлах тохиолдолд дэмжлэг үзүүлэх | Тухай бүр | ТЗУГ / Хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн / Газар, хэлтэс |
| 26. | Баяр ёслол, амралтын өдрүүдийг хамт олноороо тэмдэглэн өнгөрүүлэх, аялал зугаалга зохион байгуулах, урлаг спортын арга хэмжээ зохион байгуулах зэргээр хамт олны уур амьсгалыг зөв төлөвшүүлэх, албан хаагчдын үр бүтээлтэй амрах, алжаалаа тайлах нөхцөл бололцоогоор хангана. | 24.1 ЗТХЯ-ны хэмжээнд 2021 онд тэмдэглэлт өдөр, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах хуваарийг баталж, хэрэгжүүлэх | Жилдээ | ТЗУГ /П.Насанжаргал, Э.Бадамсүрэн/ Газар, хэлтэс |
| | | 24.2 Байгууллагын соёл, зохион байгуулалт, хүний нөөцтэй холбоотой асуудлаар сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, үнэлэлт дүгнэлт хийж ажиллах | 11 дүгээр сард | ТЗУГ /Ш.Мөнхбулган/ Газар, хэлтэс |
| 27. | Байгууллага, хамт олноороо ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх болон бусад нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажлыг зохион байгуулж, албан хаагчдын нийгмийн хүрээн дэх байр суурийг өргөжүүлнэ. | 25.1 Ахмад, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хүмүүнлэгийн ажлыг зохион байгуулах | Жилдээ | Газар, хэлтэс |
| **Долоо. Албан хаагчийн гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд:** | | | | |
| 28. | Төрийн албан хаагчийн амьдарч буй орчин | 26.1 Албан хаагчдын нийгмийн асуудлаар гаргасан | Жилдээ | ТЗУГ |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | нөхцөл, гэр бүлийн гишүүдийнх нь боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлтийн байдал зэрэг мэдээллийг агуулсан судалгаатай байна. | судалгааг шинэчилж, гэр бүлийн гишүүдтэй холбоотой нэмэлт мэдээллийг бүрдүүлэх | | / Гэр бүлийн зөвлөл / |
| 29. | Гэр бүлийн гишүүдийн дотор тусгай арчилгаа шаарддаг хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн байдаг бол тухайн ажилтанд гэр бүлийн гишүүнээ асрахад нь зориулсан дэмжлэг туслалцаа үзүүлнэ. | 27.1 Хөдөлмөрийн чадвараа алдсан гэр бүлийн гишүүнээ тэтгэх, ажилтны өрхийн орлого буурч нэг гишүүнд ноогдох хэмжээ нь амьжиргааны баталгаажих доод түвшинд хүрэхгүй болсон, ар гэрт нь гачигдал тохиолдсон зэрэг нөхцөлд байгууллагаас нэг удаагийн тэтгэмж, тусламж олгох асуудлыг судлан шийдвэрлэх | Тухай бүр | ТЗУГ<br>/ Э.Бадамсүрэн / |
| | | 27.2 Албан хаагчдын гаргасан хүсэлтийн дагуу гэр бүлийн гишүүнээ асрахад нь зориулж чөлөө олгох асуудлыг Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу тухай бүр шийдвэрлэх | Тухай бүр | ТЗУГ<br>/ Э.Бадамсүрэн / |
| 30. | Шинээр гэр бүл болж байгаа болон залуу гэр бүлийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. | 28.1 Шинээр гэр бүл болж байгаа албан хаагчдад дэмжлэг үзүүлж, нэг удаагийн буцалтгүй тусламж олгох асуудлыг шийдвэрлэх | Тухай бүр | ТЗУГ<br>БТГ, ХОҮХ |
| | | 28.2 Шинээр гэр бүлж байгаа болон гэрлэлтээ батлуулсан боловч гэрлэх ёслолын ордонд ёсолж амжаагүй албан хаагчдын гэрлэх ёслолын ордонд ёслох арга хэмжээг зохион байгуулах. | 3-5 сард | ТЗУГ<br>/хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн/ |

--oOo--